*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН АНХАН БОЛОН ЛАВЛАГАА ШАТЛАЛЫН ТУСЛАМЖИЙН ХЭЛТСИЙН ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ МААМХҮҮ ОВОГТОЙ ОЮУНЧИМЭГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / сүүлийн хагас жилийн биелэлт/ | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| 1 | 2 | 3 | 4 | | 5 | | |
| **"Зорилт 1. "Төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээний урт, дунд, богино хугацааны бодлого, бодлогын хэрэгжилтийн нэгдсэн зохион байгуулалт, зохицуулалт"** | | | | | | | |
| 1 | ***Арга хэмжээ 1.1.*** *УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол МУ-ын ЗГ-ын 2024 оны 181 дүгээр тогтоол ЗГҮАХ-ийн 2.3.2.2 дахь заалт* ~~ЗГҮАХХАХТ-2.3.2.2.424~~ Эмнэлгийн тусламжийн тухай хууль шинэчлэн боловсруулах (Шинэчилсэн найруулга) | Батлагдсан үзэл баримтлал | 2016 онд батлагдсан Эрүүл мэндийн тухай хууль | Ажлын хэсгийг байгуулж, хууль боловсруулах ажлын нарийвчилсан төлөвлөгөө гарган, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалж, хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн байна. | Эрүүл мэндийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/43 дугаар тушаалаар Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Хуулийн төсөл боловсруулах хүрээнд дараах үйл ажиллагааг хийж байна.<br>• Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандах судалгааг хийж байна.<br>• Хуулийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээ хийж байна.<br>• Хууль дагаж гарах захиргааны актын судалгаа хийсэн<br>• Шинэчлэн боловсруулж байгаа Эрүүл мэндийн тухай хууль Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулт, Эмнэлгийн мэргэжилтний эрхзүйн байдлын тухай хуулийн ажлын хэсэгтэй зөвшилцөн хуулийн үйлчлэх хүрээг тус тусад нь хуваах тодорхойлсон.<br>• Ажлын хэсгээс Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулаад байна. | 02-12 | 80% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2 | ***Арга хэмжээ 1.2.***<br>*ЗГҮАХ-ийн 2.3.2.1 дэх заалт*<br>*МУ-ын ЗГ-ын 2024 оны 181 дүгээр тогтоол*<br>Цусны донорын тухай хуульд санал боловсруулах (Анхдагч хууль) | Санал хүргүүлсэн албан бичиг | Хуулийн төсөл | Хуулийн төсөлд санал авах арга хэмжээг зохион байгуулж, боловсруулан албан бичгээр хүргүүлсэн байна. | Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгээс санаачлан боловсруулсан "Цусны донорын тухай" хуулийн төсөлд Дотоод меморандум 73-аар ЭМЯ-ны газар, хэлтсээс, эрүүл мэндийн байгууллагуудаас 5/1226 дугаар албан бичгээр санал авч нэгтгэн, Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн удирдлагын багт танилцуулах уулзалтыг зохион байгуулж, МУ-ын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороонд Эрүүл мэндийн сайдын 1а/2785 албан бичгээр хүргүүлсэн.<br>Хууль шинэчлэхтэй холбоотой дараах хуралд мэдээлэл бэлтгэн оролцсон байна.<br>• УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн хуралдаанд "Донорын хууль-ийн хэрэгжилтийн талаар мэдээлэл бэлтгэн танилцуулж, хэлэлцүүлсэн.<br>• УИХ-ын 2025 оны Нийгмийн бодлогын байнгын хорооны 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанд Цусны донорын хуулийн анхдагч хуулийн төслийг хэлэлцүүлж дэмжигдсэн.<br>• УИХ-ын 05 дугаар сарын 22-ны хуралдаанд Цусны донорын хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг шийдэх хурал болсон. | 03-04 | 100% |
| 3 | ***Арга хэмжээ 1.3.***<br>*Эрүүл мэндийн тухай хуулийн 8.8 дахь заалт*<br>Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг улсын хэмжээнд бусад эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангах тусламж, үйлчилгээний чиглэл, хамрах хүрээг шинэчлэх | Батлагдсан тушаал | Хүрээ шинэчлэх тухай тушаалын төсөл | Улсын хэмжээнд мэргэжил аргазүйгээр хангах тусламж, үйлчилгээний чиглэл болон тушаалын төслийг боловсруулж хэлэлцүүлсэн байна. | Тусламж, үйлчилгээний хүрээ, үйлчлэх эрүүл мэндийн байгууллагын хуваарь баталсан тушаалуудын зохицуулалт хоорондоо зөрчилтэй, алдаатай байгаагаас эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэх үйл ажиллагаанд үл ойлголцол үүсэх, үүнээс үүдэлтэй үйлчлүүлэгчийг чирэгдүүлэх, цаашлаад эмчилгээний хожимдол үүсэх нөхцөл байдалд хүрсэн байгааг хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээ хийж гарган дараах хүрээг шинэчлэн боловсруулж ЭМЯ-ны удирдлагуудаас санал авч байна.<br>• "Улсын хэмжээнд эрүүл мэндийн бусад байгууллагыг арга зүйгээр хангах тусламж, үйлчилгээний хуваарь" | 02-09 | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | • "Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээнд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх хүрээ<br>• "Зүрхний шигдээсийн үед судсан дотуурх оношилгоо, эмчилгээ хийх эрүүл мэндийн байгууллагын үйлчлэх хүрээ"<br>• "Нийслэлд гемодиализийн тусламж, үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын үйлчлэх хүрээ" | | |
| 4 | ***Арга хэмжээ 1.4.***<br>*ЗГҮАХ 2.1.1.14.187*<br>"Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд" арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан | | "Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн албан хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам"-ыг эмнэлгийн мэргэжилтнүүдэд сурталчлах, ажлыг зохион байгуулсан байна. | Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн албан хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам"-ыг эмнэлгийн мэргэжилтнүүдэд сурталчлах, ажлыг зохион байгуулах хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулж, үр дүн тайлан мэдээллийг Батлан хамгаалахын сайдад 1а/3001 албан бичгээр хүргүүлсэн.<br>• Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт 5/654 албан бичгээр жил бүр зохион байгуулагддаг цэрэг татлагаар эрүүл мэндийн шалтгаанаар чөлөөлөгдсөн иргэдийн тоо нэмэгдэх хандлагатай байгаад анхаарч орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх 4 чиглэлийг хүргүүлж, тайлан мэдээллийг авч нэгтгэсэн.<br>• Нийтийн эрүүл мэндийн газарт 37 дугаар дотоод меморандумаар цэргийн насны иргэдийн эрүүл мэндийн байдлыг судлах, хянах, үнэлэх эрэлт хэрэгцээнд үндэслэн нийгмийн эрүүл мэндийн бодлогыг тодорхолж ажиллах саналыг хүргүүлсэн.<br>• Батлан хамгаалах яамнаас зохион байгуулсан "Цэрэг татлага 2023" улсын зөвлөгөөнд "Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн байдал, цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгт анхаарах асуудал" сэдвээр илтгэл бэлтгэн танилцуулж оролцсон.<br>• 2025 оны 05 дугаар сарын 01-ны өдөр "Цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр | 02-09 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тэнцүүлэх үйла жиллагаанд анхаарах нь" сэдэвт цахим хурлыг аймаг, нийслэлийн эрүүлм эндийн байгууллага, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Мэргэжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнтэй зохион байгуулж МУ-ын ЗГ-ын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 140 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаар илтгэл мэдээлэл танилцуулж, оролцогчидтой санал солилцсон. | | |
| 5 | ***Арга хэмжээ 1.5.*** *Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.4 дэх заалт* Эмнэлэг болон сувиллын орны дээд хязгаарыг тогтоох | Батлагдсан тушаал | | Улсын хэмжээнд хэвтүүлэн эмчлэх ор ашиглалтын судалгаа хийсэн байна. | Эрүүл мэндийн хуулийн 8.1.4.хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг салбарын хэмжээнд төлөвлөх, зохион байгуулах, эрүүл мэндийн байгууллагын байршил, бүтэц, зохион байгуулалт, тусламж, үйлчилгээний төрөл, шатлал, эмнэлгийн болон сувиллын орны дээд хязгаарыг тогтоох;" гэж хуульчилсны дагуу 2026-209 оны эмнэлгийн тусламж, үйлчилгээнд ашиглах орны дээд хязгаарыг батлах эрхзүйн үндэслэлийн хүрээнд хэвтүүлэн эмчлэх орыг дахин төлөвлөхөд нотолгоот мэдээллийг гаргах зорилгоор эмнэлгийн орны ашиглалтын байдалд судалгаа дүн шинжилгээ, хийх ажлыг ЭМХТ—тэй хамтран гүйцэтгээд байна. | 07-12 | 100% |
| 6 | ***Арга хэмжээ 1.6.*** *Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 11.2 дахь заалт* Жолоочийн эрүүл мэндэд тавих шаардлага, жолоочийн эрүүл мэндийн үзлэг явуулах журам, үзлэгийн хуудасны загвар, үзлэг явуулах эрх бүхий эмнэлгийн байгууллагын | Батлагдсан тушаал | - | Хууль дагаж гарах журам, жагсаалтыг боловсруулах ажлыг бүрэлдэхүүн, ажиллах, удирдамжийг баталгаажуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган, төслүүдийг боловсруулсан байна. | Хууль дагаж гарах журам, жагсаалтыг боловсруулах бэлтгэл ажлын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллгаа:<br>• Эрүүл мэндийн сайдын 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/80 дугаар тушаалаар Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль дагаж гарах журам, шаардлага, жагсаалт, үзлэгийн хуудсын загвар боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын удирдамжийг баталсан.<br>• Ажлын хэсгийн хурлыг нэгдсэн хурлыг 1 удаа зохион байгуулж, эрүүл мэндийн шаардлага тавигдах мэргэжлийн чиглэлүүдийн түвшинд (нүд, чих, хамар, хоолой, мэдрэл, гэмтэл) 5 удаагийн уулзалт зохион байгуулаад байна. | 01-09 | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | жагсаалт, тээврийн хэрэгсэл жолоодоход харшлах эм, бэлдмэл, тээврийн хэрэгсэлд байх эмийн сангийн иж бүрдлийн жагсаалт, зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн тусламж үзүүлэх журам боловсруулж батлуулах | | | | • Журам боловсруулах хүрээнд "Зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн тусламж, үзүүлэх журам"-ын талаар ОУ-ын судалгаа хийсэн.<br>• Жолооны эрх ба эрүүл мэндийн хязгаарлалтын талаарх ОУ-ын туршлагын судалгаа хийсэн.<br>• Оросын Холбооны Улс, Герман Улсын тээврийн хэрэгсэлд байх эмнэлгийн анхан шатны тусламжийн иж бүрдэлд байх эм, эмнэлгийн хэрэгслийн мэдээллийг гаргасан.<br>• ажлын хэсэг Жолоочийн эрүүл мэндэд тавих шаардлага, жолоочийн эрүүл мэндийн үзлэг явуулах журам, үзлэгийн хуудасны загвар, тээврийн хэрэгсэлд байх эмийн сангийн иж бүрдлийн жагсаалтын төслийг боловсруулаад байна. | | |
| 7 | ***Арга хэмжээ 1.7.***<br>*Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 25.2*<br>Хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж, үзүүлэх түүнийг эрүүл мэндийн байгууллагад эмчлэх, хорих байранд эмнэлгийн мэргэжилтэн ирж үйлчлэх журамд нэмэлт өөрчлөлт оруулах | Батлагдсан тушаал | ЭМС, ХЗДХС, хамтарсан 2019 оны А/142, А/47 дугаар | Нөхцөл байдлыг судалж, журамд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж, ХЗДХС-д хүргүүлж, саналыг тусган батлуулсан байна. | Эрүүл мэндийн сайд, Хууль, зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/211, А/218 дугаар тушаалаар батлагдсан. Эрүүл мэндийн байгууллагуудад 5/2945 дугаар албан бичгээр хэрэгжилтийг хангах чиглэлийг хүргүүлсэн. | 01-06 | 100% |

**Зорилт 2. "Төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээний байгууллагын үйлчилгээний хүлээгдэл чирэгдлийг бууруулах үйл ажиллагааны зохицуулалт"**

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | ***Арга хэмжээ 2.1.*** Эрүүл мэндийн байгууллага болон шатлал хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх эрхзүйн орчныг шинэчлэх, зохицуулалтыг сайжруулах арга хэмжээг авах | Батлагдсан тушаал | ЭМС-ын 2021 оны А/183 дугаар тушаал | Өвчтөн шилжүүлэх журмын төслийг боловсруулж батлуулсан байна. | Эрүүл мэндийн байгууллага хооронд өвчтөн илгээх журмыг шинэчлэх хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулсан.<br>• Өвчтөн илгээх 13А, 13Б маягтыг шинэчлэн 89 А, Б маягт болгон өгөгдлийг шинэчлэн боловсруулсан.<br>• Эмнэлэг хооронд цахимаар өвчтөн шилжүүлэх үйл ажиллагааг хавдрын тусламж, үйлчилгээнд турших үйл ажиллагааг 06 дугаар сараас зохион байгуулж эхэлсэн бөгөөд туршилтын үр дүнд үндэслэн өвчтөн шилжүүлэх үйл ажиллагааг журамлаж тушаалаар батлана.<br>• Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/102 дугаар тушаал Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах ажлын хэсгийн хүрээнд анхан шатны бүртгэлийн маягтын бүртгэлийн давхардлыг арилгах дүн шинжилгээ хийгдэж байна. | 01-12 | 50% |
| 9 | ***Арга хэмжээ 2.2.*** Алсын дуудлагаар очиж эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрхзүйн орчныг шинэчлэх, нэгдсэн удирдлага зохион байгуулалтын тогтолцоог бүрдүүлэх журмыг шинэчлэх | Батлагдсан тушаал<br>Зохицуулалт хийдсэн тоон мэдээлэл | ЭМС-ын 2014 оны А/263 дугаар тушаал | Алсын дуудлагын журмын төслийг боловсруулж батлуулсан байна. | Алсын дуудлагаар эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журмын төслийг боловсруулж, Эрүүл мэндийн яамны вэб хуудсанд санал авахаар байршуулсан.<br>бөгөөд салбарын цахим шинэчлэлийн хүрээнд программын нийцэл бүрэн хангагдсан үед мэдээллийн урсгалыг журамд нэмж оруулах шаардлага хүлээгдэж байна. | 01-12 | 50% |
| 10 | ***Арга хэмжээ 2.3.*** Нийслэлийн хэмжээнд ахмад настны үзлэгийн зохион байгуулах | Батлагдсан тушаал | - | Нийслэлд 2-3 дугаар сард ахмад настны үзлэг зохион байгуулах шийдвэрийг батлуулж, хэрэгжилтийг хангуулахад | Нийслэлийн хэмжээнд ахмад настны үзлэгийн зохион байгуулах үйл ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулсан:<br>• Нийслэлд "Ахмад настны үзлэгийг зохион байгуулах ажлын удирдамж"-ийг боловсруулж Эрүүл мэндийн сайдын 2025 оны 01 дүгээр | 02-03 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | удирдлага арга зүйн дэмжлэг үзүүлсэн байна. | сарын 31-ний өдрийн А/28 дугаар тушаалаар батлуулсан.<br>• Ахмад настны үзлэгийг зохион байгуулах үйл ажиллагаанд мэргэжил аргазүйгээр хангах зорилгоор нийслэлийн төрийн өмчийн бүх байгууллагуудад цахим хурлыг зохион байгуулж явцын хяналтыг 7 хоног хийж тайланг гаргасан.<br>• Нийслэлийн хэмжээнд 2 сарын хугацаанд зохион байгуулагдсан үзлэгт **7337** ахмад хамрагдаж, 1593 ахмадыг дүүргийн эрүүл мэндийн байгууллага, 999 ахмадыг төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн хяналтад авсан. | | |
| 11 | ***Арга хэмжээ 2.4.***<br>Нийслэлийн мэс заслын тусламжийн хүрээг тогтоох эрхзүйн орчныг бусад эрхзүйн орчинтой нийцүүлж шинэчлэх | Батлагдсан тушаал | ЭМС-ын 2022 оны А/424 дүгээр тушаал | Нийслэлийн мэс заслын тусламжийн хүрээг тогтоох эрхзүйн шинэчлэн батлуулсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/111дүгээр "Нийслэлийн хүн амд үзүүлэх мэс заслын тусламж, үйлчилгээний хүрээ шинэчлэн батлах тухай" тушаалыг боловсруулан батлуулсан. | 02-05 | 100% |
| 12 | ***Арга хэмжээ 2.5.***<br>ЗГҮАХ 2.1.4.3.291<br>Анхан шатны спортын сургалт, дасгалжуулалтын үр дүнг сайжруулж, спортын шинжлэх ухаан, спортын анагаах ухааны тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Шинээр нэвтрүүлсэн технологийн тоо | 2024 онд спортын гэмтлийн төв байгуулагдсан | Спортын гэмтэлд үзүүлэх тусламж, үйлчилгээнд шинэ технологийг нэвтрүүлсэн байна. | Гэмтэл согог судлалын үндэсний төвд шинээр байгуулагдсан "Спортын гэмтлийн төв" спортын гэмтлийн тусламж, үйлчилгээнд дараах шинэ технологийг нэвтрүүлсэн.<br>1. Ясны блокийн тусламжтайгаар мөрний үений тогтворгүйтэхийг жижиг зүслэгээр эмчлэх мэс заслыг 10 үйлчлүүлэгчид хийж эмнэлзүйн нэвтрүүлсэн.<br>2. Шагайн үений тогтворгүйтэхийг дурангийн мэс заслын аргаар эмчлэх мэс заслыг хийж эхэлсэн<br>3. Дурангийн аргаар хиймэл арьсны тусламжтайгаар мөрний капсулитыг эмчлэх мэс заслыг хийж эхэлсэн. | 01-12 | 100% |
| 13 | ***Арга хэмжээ 2.6.***<br>УГТЭ, ХӨСҮТ-ийн эрүүл мэндийн тусламж, | Үйл ажиллагааны тайлан | | Ажлын хэсэг байгуулж, эрүүл мэндийн | Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын хамтарсан "Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн үзүүлж | 04-06 | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээний онцлог байдал, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг судалж дүгнэлт гаргах | | | байгууллагад ажилласан байна. | байгаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний онцлог байдал, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой үүсэж байгаа асуудлыг судалж дүгнэлт гаргах" ажлын хэсгийг 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/70, А/36 дугаар тушаалаар байгуулж, нарийн бичгийн даргаар ажилласан. Ажлын хэсгийн ажлын удирдамжийг боловсруулж батлуулсан.<br>ХӨСҮТ-ийн нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, УХТЭ-ийн төрийн өндөр албан тушаалтны үйлчилгээтэй холбоотой санхүүгийн өр үүссэн шалтгааны дүгнэлт, цаашид шийдвэрлэх арга замын зөвлөмжийг ажлын хэсгээс боловсруулсан. | | |
| **Зорилт 3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний стандарт заавар шинэчлэх, нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах** | | | | | | | |
| 14 | ***Арга хэмжээ 3.1.*** Улаанбурхан өвчний зааврыг шинэчлэх | Батлагдсан тушаал | ЭМС-ын 2024 оны 91 дүгээр тушаал | Улаанбурхан өвчний зааврыг шинэчлэн боловсруулж батлуулсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/81 дүгээр тушаалаар "Улаанбурхан өвчний эмнэлзүйн заавар"-ыг боловсруулж батлуулсан. | 03-04 | 100% |
| 15 | ***Арга хэмжээ 3.2.*** Зүрхний шигдээсийн эмнэлзүйн зааврыг шинэчлэн боловсруулах | Батлагдсан тушаал | | Зүрхний шигдээсийн эмнэлзүйн зааврын төслийг боловсруулсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/227 дугаар тушаалаар Зүрхний шигдээсийн эмнэлзүйн заавар"-ыг шинэчлэн боловсруулж батлуулсан. | 01-12 | 100% |
| 16 | ***Арга хэмжээ 3.3.*** Зүрхний цочмог дутлын зааврыг шинээр боловсруулж батлуулах | Батлагдсан тушаал | - | Зүрхний цочмог дутлын зааврын төслийг боловсруулсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/228 дугаар тушаалаар Зүрхний цочмог дутмагшлын оношилгоо, эмчилгээний заавар"-ыг шинээр боловсруулж батлуулсан. | 01-12 | 100% |
| 17 | ***Арга хэмжээ 3.4.*** Ахалази өвчний эмнэлзүйн зааврыг шинээр боловсруулж, батлуулах | Батлагдсан тушаал | - | Ахалази өвчний зааврын төслийг боловсруулсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/229 дүгээр тушаалаар "Ахалази өвчний эмнэлзүйн заавар"-ыг шинээр боловсруулж батлуулсан. | 01-12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 18 | ***Арга хэмжээ 3.5.*** Целиак өвчний эмнэлзүйн зааврыг шинээр боловсруулж, батлуулах | Батлагдсан тушаал | - | Целиак өвчний заврын төслийг боловсруулсан байна. | Целиак өвчний заврын төслийг боловсруулж, санал авахаар ЭМЯ-ны вэб хуудсанд байршуулсан. | 01-12 | 100% |
| 19 | ***Арга хэмжээ 3.6.*** Кроны өвчний эмнэлзүйн зааврыг шинээр боловсруулж батлуулах | Батлагдсан тушаал | - | Кроны өвчний заврын төслийг боловсруулсан байна. | Кроны өвчний заврын төслийг боловсруулж, санал авахаар ЭМЯ-ны вэб хуудсанд байршуулсан. | 01-12 | 100% |
| 20 | ***Арга хэмжээ 3.7.*** Нүүрс хүчлийн хийний хордлогын үеийн оношилгоо эмчилгээний зааврыг шинээр боловсруулж, батлуулах | Батлагдсан тушаал | - | Нүүрс хүчлийн хийний хордлогын үеийн оношилгоо эмчилгээний заврын төслийг боловсруулсан байна | Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/230 дугаар тушаалаар "Нүүрс хүчлийн хийний хордлогын үеийн оношилгоо эмчилгээний заавар"-ыг шинээр боловсруулж батлуулсан. | 01-12 | 100% |

**ХОЁР. НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР(арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | ***Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.*** "Согтуурах, мансуурах донтох эмгэгтэй хүнд эрүүл мэнд, нийгэм, сэтгэлзүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх "Сэргээн засах төв" байгуулах ажлыг судалж, жишиг төв байгуулах үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллах | Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан | | Ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж, хурлын зохион байгуулалт, ажлын төлөвлөгөөг боловсруулж ажлын хэсгийг салбарын мэдээллээр хангасан байна. | ХЗДХС-ын 2025 оны А/142 дугаар тушаалаар байгуулагдсан "Согтуурах, мансуурах донтох эмгэгтэй хүнд эрүүл мэнд, нийгэм, сэтгэлзүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх "Сэргээн засах төв" байгуулах ажлыг судалж, жишиг төв байгуулах үүрэг бүхий ажлын хэсэгт нарийн бичгийн даргаар ажиллаж, 2 удаагийн ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, "Согтуурах мануурах донтой өвчтэй хүнийг эмчлэх сэргээн засах төв байгуулах | 01-12 | 100% |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | ажлын төлөвлөгөөний төслийг боловсруулсан. | | |
| 2. | ***Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2.*** "Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, харуул хамгаалалт, техник тоног төхөөрөмж, эмчлүүлэгчийн орчин нөхцөлийг сайжруулах, эрзүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллах | Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан | | ХЗДХС, ЭМС-ын хамтарсан тушаалаар ажлын хэсгийг батлуулах, ажлын хэсгийг салбарын мэдээллээр хангасан байна. | ХЗДХС, ЭМС-ын хамтарсан 2025 оны А/119, А/140 дүгээр тушаалаар батлагдсан "Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, харуул хамгаалалт, техник тоног төхөөрөмж, эмчлүүлэгчийн орчин нөхцөлийг сайжруулах, эрзүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/240, А369 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам"-ыг шинэчлэх саналыг боловсруулж ХЗДХС-ад 1а/2856 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 04-12 | 100% |
| 3 | ***Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3.*** МУ-ын Их Хурлын даргын 98 дугаар захирамжаар байгуулагдсан "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох асуудлыг судлан дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох | Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан | | Ажлын хэсгийн үйл ажиллагаанд зохион байгуулалтаар дэмжлэг үзүүлэх, хурлаар хэлэлцүүлэх асуудлын | МУ-ын Их Хурлын даргын 98 дугаар захирамжаар байгуулагдсан "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох асуудлыг судлан дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг ажиллаж, эрүүл | 04-12 | 100% |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг ажиллах | | | мэдээллийг бэлтгэх | мэндийн яамнаас танилцуулах илтгэл мэдээллийг бэлтгэж 3 удаагийн хуралд оролцоод байна. | | |
| 4 | ***Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4.*** ЭМЯ-ны төлөвлөгөөнд орох ажлын саналыг өгөх, Газрын 2025 оны төлөвлөгөөг боловсруулах, Газрын 4, 5 дугаар сарын төлөвлөгөөг боловсруулж батлуулах, 7 хоног, сар бүрийн тайланг нэгтгэн гаргах | Хэрэгжилтийн тайлан | | Газрын төлөвлөгөөг батлуулсан байна. Саруудын тайланг гарган удирдлагуудад танилцуулсан байна. | Газрын хамт олонд төлөвлөгөө боловсруулахад анхаарах асуудлын талаар мэдээлэл танилцуулж, ЭМЯ-ны төлөвлөгөөнд орох ажлыг боловсруулж, Газрын төлөвлөгөөний төслийг боловсруулж батлуулсан. Яамны төлөвлөгөө батлагдаагүйтэй холбоотой 4,5 сард хийх ажлын төлөвлөгөөг газрын хэмжээнд боловсруулан батлуулж, хэрэгжилтийг 7 хоногоор гарган тайланг нэгтгэж ажиллаж байна. | 01-12 | 100% |
| 5 | ***Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5.*** Ерөнхийлөгчийн эмчийг шинээр томилж, ажиллаж байгаа эмчийг чөлөөлөх тушаалыг боловсруулж батлуулах *(нууц)* | Батлагдсан тушаал | | УХТЭ-ийн саналыг үндэслэн ЭМС-дад холбогдох материалыг танилцуулан томилох, чөлөөлөх тушаалыг албажуулсан байна. | Эрүүл мэндийн сайдын дугаар тушаалаар *(нууц)* Ерөнхийлөгчийн эмчийг шинээр томилж, ажиллаж байгаа эмчийг чөлөөлөх тушаалыг боловсруулж батлуулсан. | 02-03 | 100% |

## ГУРАВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | | Гүйцэтгэлийн түвшин |
|---|---|---|---|

| | | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | ***Арга хэмжээ 1.*** Албан тушаалын онцлогоос хамаарсан шаардлагатай ур чадварыг эзэмших сургалтад хамрагдах | Сургалтад хамрагдсаныг илтгэх нотлох баримт | | Сургалтад хамрагдсан байна | • Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн шуурхай удирдлагын төвийн 5 хоногийн дадлага, сургуулилтад хамрагдсан. | 01-12 | 100% |
| 2 | ***Арга хэмжээ 2.*** Хариуцсан чиг үүргийн хүрээнд судалгааны багт ажиллах, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу ажлын хэсэгт ажиллах | Судалгаа хийсэн болон ажлын хэсэг ажилласан нотлох баримт | | Хийсэн судалгаа, ажилласан ажлын хэсгийн мэдээлэл | 1. ЭМС-ын 2025 оны А/32 дугаар тушаалаар батлагдсан "Глобал сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр 2024-2025 онд Эрүүл мэндийн яаманд нийлүүлэгдсэн хөрөнгийг тушаалын дагуу холбогдох газруудад олгосон эсэхэд хяналт тавих зорилгоор дотоодын хяналт, шалгалтын ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж байна.<br>2. ЭМС-ын 2025 оны А/79 дүгээр тушаалаар батлагдсан МУ-д эмчлэгдэх боломжгүй өвчний улмаас зайлшгүй шаардлагаар болон өөрийн хүсэлтээр гадаад оронд эмчилгээнд хамрагдсан иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохион байгуулах журмыг боловсруулах ажлын хэсэгт ажиллаж байна.<br>3. ЭМС-н 2025 оны А/116 дугаар "Жендерийн салбар зөвлөл"-д томилогдон төлөвлөгөөний төсөлд санал өгсөн.<br>4. ЭМС-ын 2025 оны А/210 дугаар тушаалаар байгуулагдсан | 01-12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх эрзүйн орчныг сайжруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байна.<br>5. ЭМС-ын 2025 оны А/102 дугаар тушаалаар батлагдсан Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах ажлын хэсэгт ажиллаж байна.<br>6. Нүүр амны тусламж, үйлчилгээний халдварын сэргийлэлт, хяналтын заавар боловсруулах ажлын хэсэгт ажиллаж байна.<br>7. Сэтгэцийн эрүүл мэндийн талаарх судалгаа мэдээллийг боловсруулж, МУ-ын Их Хурлын Тамгын газрын парламентын судалгаа хөгжлийн хүрээлэнд албан бичгээр хүргүүлсэн.<br>8. Удирдлагаас өгсөн үүргийн дагуу | | |
| | | | | | УИХ-ын НББХ-нд танилцуулах илтгэл, УИХ-ын 98 дугаар захирамжаар батлагдсан ажлын хэсэгт танилцуулах илтгэл, гм мэдээллийг бэлтгэсэн. | | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ТУСЛАМЖ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ ......................../М.ОЮУНЧИМЭГ/

2025.06.13